

ГЭР БҮЛИЙН

У Д И Р Д А М Ж

ГЭР БҮЛИЙН

У Д И Р Д А М Ж

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс
хэвлэн гаргав.
Солт Лэйк Сити, Юта.

© 1992, 1999, 2001 “Intellectual Reserve, Inc.”

Бүх эрхийг эдэлнэ.

АНУ-д хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 3/01

Орчуулгын зөвшөөрөл: 3/01

Family Guidebook-ийн орчуулга
Mongolian

Агуулга

“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”	iv
Гэр Бүлийн Бүтэц ба Зорилго	1
Сайн Мэдээг Гэртээ Заах нь	5
Пристийн Зэрэгтний Үндсэн Үүргүүд	14
Удирдлагын Сургалт	18
Гэр Бүл Сүмийн Нэгж Болох нь	19
Пристийн Зэргийн Ёслолууд ба Адислалууд	21
Сүмийн Материалуудыг Олж Авах ба Гэр Бүлийн Түүхийн Тухай Мэдээлэл Цуглуулах нь	29

Хуваарилалт

Гэр Бүлийн Удирдамжийг ялангуяа шинээр элсэгч, эсвэл Сүмтэй сайн танилцаж амжаагүй байгаа хүмүүс болон бүх гишүүдэд зориулсан юм. Энэ нь гэр бүлийн зохион байгуулалт болон зорилгыг тоймлож өгдөг бөгөөд гэр бүлдээ сайн мэдээг хэрхэн зааж, гэр бүлийнхээ үүрэг хариуцлагуудыг хэрхэн биелүүлэх, гэр бүл нь яаж Сүмийн нэгж болж чадах болон хэрхэн ёслолыг үйлдэж, пристийн зэргийн адислалуудыг өгөх тухай мэдээллийг агуулдаг.

“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”

1995 онд Тэргүүн Зөвлөл болон Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгаас “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг гаргасан билээ. Энэхүү тунхаг нь Сүмийн түүхийн явцад бошиглогчдын дахин давтан мэдэгдсэн сургаал, заншлуудын тайлбар хийгээд батламж болдог. Энэ нь гэр бүл бүрийн аз жаргал, сайн сайхны чухал зарчмуудыг агуулдаг. Гэр бүлийн гишүүд тунхагийг судалж түүний зааврын дагуу амьдрах ёстой.

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

“Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

“Мөнх бус байдлын өмнөх амьдралдаа сүнслэг хөвгүүд, охид Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширдэг байсан бөгөөд мөнхийн амьдралыг өвлөн авах

тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа гэр бүлийн холбоог мөнхжих боломж олгодог. Ариун Сүмүүдэд гүйцэтгэдэг нандин ёслол ба гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы хүрээлэлд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжтой болгодог.

“ Адам, Ева хоёрт Бурханы өгсөн анхны зарлиг нь тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. Өөрийн хүүхдүүддээ, өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэх хэмээсэн Бурханы зарлиг нь хүчин төгөлдөр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна.

“Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь Тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний чухал ач холбогдлын талаар бид батлан хэлж байна.

“Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээнэ. ‘Үр хүүхэд бол Их Эзэний өв юм’ (Дуулал 127:3). Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр, нөхөр—эцэг, эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

“Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, нанманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөл-

мөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь хэрэгтэй үед туслан дэмжвэл зохино.

“Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

“Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах эдгээр арга замыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна” (*Ensign*, Nov. 1995, 102).

Гэр Бүлийн Бүтэц ба Зорилго



Бүтэц

Гэр бүл бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Үндсэн нэгж бөгөөд цаг үе болон мөнхөд хамгийн чухал нийгмийн нэгж юм. Бурхан хүүхдүүддээ аз жаргалыг авчирч, тэднийг хайраар дүүрэн орчинд зөв зарчмуудаас су-



ралцуулж, мөнхийн амьдралд бэлтгэхийн тулд гэр бүлүүдийг бий болгосон бөлгөө.

Гэр орон бол сайн мэдээний зарчмуудыг заах, сурах мөн хэрэгжүүлэх хамгийн сайн газар мөн. Энэ нь хувь хүмүүс өөрсдийнхөө хоол хүнс, хувцас хунар, орон байр болон бусад зүйлсийг хангаж сурдаг газар юм. Эцэг эх нь эрх тэгш хамтрагчийн хувьд гэр бүлийн гишүүн бүрт:

- Үнэнийг эрж, Бурханд итгэх итгэлээ хөгжүүлэх.
- Нүглээ наманчлан, нүглийнхээ өршөөлийг усаар батлуулж Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн

болж Ариун Сүнсийг хүлээн авах.

- Бурханы зарлигуудыг дуулгавартай дагах, судрыг хичээнгүйлэн сурах, өдөр тутам хувийн залбирал хийж мөн бусдад үйлчлэх.
- Сайн мэдээг бусадтай хуваалцах.
- Индаумэнтээ хүлээн авч зохистой хамтрагчтай Ариун Сүмд мөнхөд гэрлэж, гэр бүлдээ аз жаргалаар дүүрэн гэр орныг үүсгэн гэр бүлээ хайр болон золиослолоор дэмжих.



- Нас барсан өвөг дээдсийнхээ талаарх мэдээллийг хайж тэдний төлөө Ариун Сүмийн ёслолуудыг гүйцэтгэх.



- Сүнслэг, нийгмийн, бие бялдрын болон сэтгэл санааны эрүүл мэндэд шаардагдах анхаарал халамж тавих.

Пристийн зэргийг атгадаг эцэг нь Сүмийн пристийн зэргийн гол албан тушаалтан байдаг. Тэрээр өрхийн тэргүүн бөгөөд патриарх юм (Ефес 5:23-г үз). Гэр бүлийнхээ пристийн зэргийн удирдагчийн хувьд тэрээр гэр бүлээ тэргүүлэн удирдаж заах, адислах болон гэр бүлийнхээ амьдралд чухал хэрэгцээт зүйлээр хангах хариуцлагатай. Тэрээр гэр бүлээ Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө эргэн очиход бэлтгэн удирддаг. Эхнэр нь түүний хамгийн чухал хамтрагч мөн зөвлөх мөн. Нөхөр эхнэр хоёр гэр бүл, орон гэртээ хамаатай бүх зүйлсийг хамтдаа зөвлөлдөх ёстой.

Эцэг нь гэр бүлийнхээ сүнслэг хэрэгцээг хангах ёстой. Тэрээр тэднийг Есүс Христийн сайн мэдээг заалгасан эсэхийг мэдэж Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагахыг урамшуулж туслахын тулд чадах бүхнээ хийх ёстой.

Зохистой бөгөөд Сүмд сонгогдох эрхтэй эцэг хүн Бурханы нэрээр үйлдэх хүч чадал, эрх мэдэл болох пристийн зэргийг атгаж болно. Энэхүү хүч чадал, эрх мэдэлтэйгээр эцэг нь гэр бүлийнхээ пристийн зэргийн удирдагч болдог. Пристийн зэргийг атгадаг эцэг нь гэр бүлийнхээ гишүүдийг адислаж тэдний сүнслэг хэрэгцээг хангаж

чаддаг. Зохих пристийн зэргийн эрх мэдлээр болоод *пристийн зэргийн удирдагчийнхаа зөвшөөрөлтэйгөөр* эцэг нь эдгээрийг гүйцэтгэж болдог:

1. Хүүхдүүддээ нэр өгч адислах.
2. Хүүхдүүдээ (мөн бусдыг) усаар батлах.
3. Хүүхдүүдээ (мөн бусдыг) Сүмийн гишүүнээр баталж, Ариун Сүнснийг тэдэнд хүртээх.
4. Хөвгүүддээ (мөн бусдад) пристийн зэргийг олгож тэднийг пристийн зэрэг дэх албан тушаалуудад нь томилох.
5. Ариун ёслолыг адислаж тараах.
6. Булшийг онцгойлон адислах.

Пристийн зэргийн удирдагчийнхаа зөвшөөрөлгүйгээр Мелкизедек Пристийн Зэрэгтэй эцэг гэр бүлийнхээ гишүүд болоод бусад хүмүүсийг өвчтэй үед нь тосыг ариулан адислаж мөн хэрэгцээтэй үед нь онцгой адислалуудыг өгч болно. (Энэ гэр бүлийн удирдамжийн х. 18–25-аас пристийн зэргийн ёслолууд ба адислалуудыг гүйцэтгэх тухай зааврыг үз.)

Эцэг нь гэр бүлээ пристийн зэргийн үндсэн 3 үүргийг биелүүлэхэд идэвхтэй оролцож буйг мэддэг.

1. Хувийн болон гэр бүлийн сүнс­лэг болоод тэр үеийн бэлэн байдал.
2. Сайн мэдээг хуваалцах.

3. Амьд хүмүүс болон нас барагс­дын төлөө хийх ёслолууд, мөн гэр бүлийн түүх ба ариун сүмийн ёслолууд

Эх хүн хүүхэд төрүүлж асран халамжлахаар адислагдсан юм. Тэрээр нөхрийнхөө эрх тэгш хамтрагч болоод зөвлөх нь мөн. Тэрээр Бурханы хуулиудыг хүүхдүүддээ заахад нь нөхөртөө тусалдаг. Хэрэв өрх гэрт эцэг байхгүй бол эх хүн гэр бүлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

Эцэг эх хоёр нэг зорилготой байх ёстой. Тэдний зорилт нь гэр бүлийн бүх гишүүдээ Тэнгэрлэг Эцэг рүүгээ эргэж очиход нь бэлтгэх явдал мөн. Тэд энэ зорилтонд хүрэхээр ажиллахдаа нэгдмэл байх ёстой. Гэр бүлдээ зааж, асран халамжлахад нь туслахын тулд Их Эзэн Сүмийг эцэг эхчүүдэд зориулан байгуулсан билээ.

Гэр бүл хүүхэдтэй болоход эцэг эх нь тэднийг хайрлаж сайн мэдээний үнэнүүдийг заах болон зөвшуударга амьдрахын үлгэр жишээ болох ёстой. Хүүхдүүд нь Бурханы зарлигуудыг сурч дагах ёстой. Тэд эцэг эхээ хүндлэн тэднийг дуулгавартай дагах ёстой.

Сүмийн хүч нь Есүс Христийн сайн мэдээний дагуу амьдрах гэр бүлүүд болон хувь хүмүүсээс хамаардаг. Сайн мэдээний адислалыг гэр бүлийн хүртэх хэр хэмжээ нь эцэг эх хоёр өөрсдийн гол үүргийг хэрхэн сайн ойлгож, биелүүлж байгаагаас

ихээхэн хамаардаг. Дааж давшгүй, урам зоригийг нь мохоох, эсвэл тэдгээр үндсэн үүргүүдийг хайхрахгүй болгох хөтөлбөр юмуу харууцлагыг эцэг эхчүүдэд Сүм өгөхийг хэзээ ч зорьдоггүй.

Зорилго

Тэнгэрлэг Эцэг маань бидэнд хайртай учраас Тэрээр биднийг өөр шигээ өргөмжлөгдөхийг хүсдэг. Тэрээр бидэнд туслахын тулд үнэний тэнгэрлэг хуулиуд дээр суурилсан дагах төлөвлөгөөг өгчээ. Энэхүү төлөвлөгөөний тухай сурч итгэлтэйгээр дагасан хүмүүс хэзээ нэгэн цагт Тэнгэр дэх Эцэгтэй адилхан болж, Түүний амьдралтай адил амьдралыг хүртэх болно.

Бидэнд зориулсан төлөвлөгөөний нэг хэсэг нь тэнгэрийг орхиж дэлхий дээр ирэх явдал байсан юм. Бид энд бие махбодыг олж туршлагаасаа суралцан өөрсдийгөө Бурхантай дахин амьдрахад зохистой гэдгээ батлан харуулдаг. Бид Түүний хуудиудыг дагахаа чөлөөтэй сонгосноороо өөрсдийн зохистой байдлыг баталдаг (Абрахам 3:23–25, 2 Нифай 2:27).

Бидэнд Тэнгэрлэг Эцэгтэйгээ амьдрах амьдралд өөрсдийгөө бэлтгэхэд туслахын тулд Тэрээр биднийг гэр бүл болгон зохион байгуулж өгсөн. Дэлхий дээрх гэр бүлүүд нь Сэлэсчэл хаант улсад байх гэр бүлүүдтэй адилхан юм.

Сайн Мэдээг Гэртээ Заах нь



Их Эзэн эцэг эхчүүдийг үр хүүхэддээ сайн мэдээг заахыг зарлигласан билээ. Тэрээр хэлэхдээ:

“Хэрэв эцэг эхчүүд Заинд, эсвэл түүний аль нэг байгуулагдсан гадсанд үр хүүхэдтэй байж, үр хүүхдүүддээ наманчлалын сургаалууд, амьд Бурханы Хүү Христэд итгэх итгэл, 8 нас хүрээд усан баталгаа хийлгэж толгой дээрээ гар тавиулан Ариун Сүнсний бэлэг хүлээн авдаг тухай ойлгоход нь туслан эдгээрийг заахгүй бол нүгэл хилэнц нь эцэг эхийн толгой дээр ирэх болно.

“Ийм учраас, энэ нь Заин болон түүний байгуулагдсан аль ч гадасны оршин суугчдад хууль байх ёстой.

“Мөн тэдний үр хүүхэд найман нас хүрэхдээ өөрсдийн нүглийн цайруулалтын төлөө усаар батлуулж, толгой дээр гар тавиулан хүлээн авах хэрэгтэй.

“Мөн эцэг эхчүүд мөн үр хүүхдүүддээ залбирах болон Их Эзэний өмнө үнэнч шуудрагаар амьдрахыг заах ёстой” гэсэн билээ (СбаГ 68:25–28).

Гэр Бүл Судраас Суралцах нь

Бид зөвхөн адислалд суурилсан хуулиудыг л дагаснаар Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болж Түүний амьдралтай адил амьдралыг хүртэж чадна (СбаГ 130:20–21-г хар). Бид тэдгээр хуулиудын дагуу

амьдрахаасаа өмнө тэдгээр нь юу вэ гэдгийг мэдэх ёстой. “Үл тоомсорлон аврагдах боломжгүй юм” (Сбаг 131:6).



Есүс Христ бол бидний удирдагч бөгөөд хуулийг өгөгч юм. Тэрээр бидний дагах замыг болоод хуулиудыг мэддэг бөгөөд биднийг өөрийгөө дага хэмээн урьсан билээ. Тэр “Би бол зам, үнэн, амь мөн. Надаар дамжихаас өөрөөр хэн ч Эцэгт минь хүрэхгүй” гэжээ (Иохан 14:6). Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болж Түүн рүү эргэж очихын тулд бид Есүсийн сургаалыг судалж, тэдгээрийг дагах ёстой. Есүс Христийн амьдрал, сургаал болон зарлигуудын тухай сурахад бидэнд туслах судрууд байдаг.

Манай Сүмд судар гэж хүлээн зөвшөөрөгдсөн дөрвөн ном нь Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ мөн Агуу Их Үнэт Сувд юм. Эдгээр судрууд нь сайн мэдээний хуулиуд болон жишгээр хэмжигддэг бидний бүх бодол, үйлдэл ба сургаалуудыг тайлбарладаг. Эдгээр нь Есүс Христийн амьдрал болон түүний сургаалуудын талаар сурахад тусалж, мөн Бурханд итгэлтэй байж Түүний зарлигуудыг бие-

лүүлж байсан хүмүүсийн жишээг бидэнд өгдөг юм.

Есүс биднийг судруудаас эрж хайн мөн сур гэж заасан байдаг (Иохан 5:39; 3 Нифай 23:1; С ба Г 88:118-ыг үз).

Гэр бүлүүд Их Эзэний сургаалыг суралцаж дагахын тулд судрыг өдөр бүр хамтдаа суралцах хэрэгтэй. Эцгүүд гэр бүлийнхнээ өдөр бүр тогтмол цагт цуглуулан судраас уншиж ярилцах ёстой. Гэр бүлийн уншиж чаддаг гишүүн бүр судраас унших боломжтой байх ёстой.

Судрын уншлагыг эхлэхийн өмнө гэр бүлийн нэг гишүүн залбирал хийж, хүн бүрийг унших зүйлээ ойлгож түүний тухай гэрчлэлтэй болохыг Тэнгэрлэг Эцэгээс хүсч болно. Судрын уншлагын цагийн дараа гэр бүлүүд гэр бүлийн залбирлаа хийхийг хүсч болно.

Гэр бүлээрээ судрыг уншин эргэцүүлэн бодсоноор тэд Аврагчтай илүү адилхан болохыг хүсэж мөн амьдралдаа агуу их аз жаргал ба амар амгаланг олж авах болно.

Хувийн болон Гэр Бүлийн Залбирлууд

Бид бүгд залбирлаар дамжуулан Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярихыг сурах ёстой. Тэнгэрлэг Эцэг маань бидэнд хайртай бөгөөд биднийг Түүнтэй ярихыг хүсдэг. Тэр биднийг адислалуудынхаа төлөө түүнд талархан, тусламж болон

зааварчилгааг нь асуугаасай гэж хүсдэг. Бид түүнээс хүсвэл Тэр бидэнд туслах болно. Бид ихэнхдээ сөгдөн сууж эсвэл зогсож байхдаа толгой гудайлган нүдээ аньж залбирдаг.

Бид залбирахдаа дөрвөн чухал зарчмыг санаж байх хэрэгтэй:

1. “Тэнгэр дэх Эцэг минь . . . ” хэмээн бид залбирлаа Тэнгэр дэх Эцэгтээ хандан эхэлдэг.
2. “Бид Танд . . . талархаж байна” хэмээн бидэнд өгсөн зүйлүүдийнх нь төлөө бид Тэнгэр дэх Эцэгтээ талархдаг.
3. “Бид Танаас . . . гуйж байна” хэмээн бид хэрэгтэй зүйлүүдийнхээ төлөө Түүнээс тусламж гуйдаг.
4. Бид залбирлаа Аврагчийн нэрээр төгсгөдөг: “Есүс Христийн нэрээр, амэн.”

Бидний залбирал үргэлж эдгээр дөрвөн үе шатыг дагах албагүй ч тэдгээрийг санаж байх нь залбирч сурахад маань тусалдаг. Бид залбирлаа ямагт эхний болоод сүүлийн үе шатаар эхлэх бөгөөд дуусгах ёстой боловч, дунд нь хэлэх зүйлс маань бидний чухал гэж үзсэн зүйлүүдээс шалтгаалах болно. Заримдаа бид залбирлынхаа ихэнхийг Тэнгэрлэг Эцэгтээ талархахад зориулахыг хүсч болно. Бусад үед бид Түүнээс тусламж гуйхад залбирлынхаа ихэнхийг зориулахыг хүсч болно.

Хувийн Залбирал



Хүн бүр өглөө оройд доод тал нь нэг удаа хувийн залбирал хийх хэрэгтэй. Эцэг эхчүүд хүүхдүүддээ ярьж чаддаг болсон мөчөөс нь хувийн залбирал хийхийг заах ёстой. Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт сөгдөн сууж, хэлсэн өгүүлбэрээ тэднээр нэг нэгээр нь давтан хэлүүлснээр хэрхэн залбирахыг тэдэнд зааж болно. Удалгүй хүүхдүүд хувийн залбирлаа хийх боломжтой болно.

Гэр Бүлийн Залбирал



Гэр бүл болгон өдөр тутам гэр бүлийн залбирал хийдэг байх ёстой. Гэр бүлээрээ сөгдөн сууцгааж, эцэг нь залбирал хийх эсвэл хэн нэгэн гэр бүлийн гишүүнээс хийхийг хүсдэг. Хүн бүр тогтмол залбирал хийх боломжтой байх хэрэгтэй. Бага насны хүүхдүүд эцэг эхийн тусламжтайгаар өөрсдийн ээлжинд залбирлаа хийж болно. Гэр бүлийн залбирал нь хүүхдүүддээ хэрхэн залбирахыг мөн Бурханд итгэх итгэл, хүнлэг чанар болон хайр энэрэл зэрэг зарчмуудыг заах маш таатай аз завшаан юм.

Онцгой Залбирал

Бурхан тэдний залбирлыг сонсоход үргэлж бэлэн байдаг гэдгийг эцэг эхчүүд хүүхдүүддээ заах ёстой. Түүнчлэн хувийн болон гэр бүлийн байнгын залбирлаас гадна тэд тусламж хэрэгтэй үед, эсвэл талархлаа илэрхийлэхийг хүссэн ямар ч үедээ залбирч болно.

Хоол Адислах



Эцэг бүр гэр бүлийн гишүүдийг хоол хүнснийхээ төлөө Бурханд та-

лархаж сурч байгаа болон идэхээсээ өмнө Түүнээс адислаж өгөхийг хүсч байгаа эсэхийг нь ажиглах ёстой. Бага насны хүүхдүүдийг оролцуулан хүн бүр адислалыг ээлжлэн хэлэх хэрэгтэй. Хоол хүнсээ адислахыг залбиран гуйх нь Тэнгэрлэг Эцэгтээ талархалтай байхыг суралцахад нь эцэг эхчүүд болон хүүхдүүдэд тусалдаг.

Гэр Бүлийн Үдэш



Гэр бүл болгон долоо хоног бүр гэр бүлийн үдэш хийх хэрэгтэй. Гэр бүл нь нэг хүн эсвэл эхнэр нөхөр хоёроос бүрдэж болно. Үүнд хүүхдүүд ба бусад төрөл төрөгсөд орж болно. Нөхцөл байдлаас үл хамааран гэр бүлийн үдшийг хийдэг гэр бүл бүр адислагдах болно. Сүм Даваа Гарагийн оройг бусад үйл ажиллагаануудаас чөлөөтэй байлгадаг тул гэр бүлүүд гэр бүлийн үдэшт хамтдаа байж чадна.

Тэргүүн Зөвлөл хэлэхдээ: “Хэрэв та нар Их Эзэний зөвлөгөөг дагаж гэр бүлийн үдшийг тогтмол хийвэл бид та бүхэнд агуу адислалуудыг амлаж байна. Сүм дэх эцэг эхчүүд маань үр хүүхдүүддээ сайн мэдээний зарчмуудыг заах болон

үлгэр жишээгээр үзүүлэх хариуцлагаа хүлээн зөвшөөрөх болно хэмээн бид үргэлж залбирдаг. Энэ маш чухал үүрэг хариуцлагадаа хичээнгүй байхад тань Бурхан та бүгдийг адислах болтугай” гэсэн билээ (“Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичиг,” *Family Home Evening Resource Book*, [1983], iv).

Гэр бүлийнхээ патриархын хувьд эцэг хүн тэргүүлдэг. Тэрээр гэр бүлийн үдшийг удирдах буюу гэр бүлийн нэг гишүүнийг удирдуулахаар томилно. Тэрээр хичээл заах юмуу эхнэртээ эсвэл хичээл заахуйц том болсон хүүхдүүддээ хичээлийг даалгана. Насанд хүрсэн хүн бүр оролцох боломжтой байх ёстой. Бага насны хүүхдүүд хөгжим удирдах, судраас иш татах, асуултанд хариулах, зураг барьж өгөх, зууш тараах болон залбирал хэлэх зэргээр тусалж чадна. Эцгийн эзгүйд эх тэргүүлнэ.

Гэр бүлийн үдэшт зориулсан санаануудыг дараах зүйлээс харж болно:

- Нээлтийн дуу (гэр бүлээрээ)
- Нээлтийн залбирал (гэр бүлийн нэг гишүүнээр)
- Шүлэг эсвэл судраас унших (гэр бүлийн нэг гишүүнээр)
- Хичээл (эцэг эх юмуу том хүүхдээр)
- Үйл ажиллагаа (гэр бүлийн нэг гишүүнээр удирдуулж, гэр бүлийн бүх гишүүд оролцоно)

- Хаалтын дуу (гэр бүлээрээ)
- Хаалтын залбирал (гэр бүлийн нэг гишүүнээр)
- Амттан

Гэр бүлийн үдшийг бусад олон арга хэлбэрээр хийж болно. Гэр бүлийг хамтад нь байлгаж, бие биенээ хайрлах хайрыг нь бэхжүүлж, тэднийг Тэнгэрлэг Эцэгт улам ойртоход нь тусалж, мөн тэднийг зөв шударгаар амьдрахад нь уриалан зоригжуулдаг ямар нэгэн үйл ажиллагаа нь гэр бүлийн үдэшт байж болно. Үйл ажиллагаануудын жишээ нь судруудаас унших, сайн мэдээнээс ярилцах, гэрчлэлээ хуваалцах, үйлчлэлийн ажил хийх, хамтдаа дуулах, зугаалгаар явах, гэр бүлээрээ тоглоом тоглох, явган аялал хийх зэрэг болно. Гэр бүлийн бүх үдэш нь залбиралтай байх ёстой.

Гэр бүлийн үдшийн хичээлүүд нь судрууд, манай хожмын үеийн бошиглогчдын үгс, ялангуяа ерөнхий чуулганы илтгэлүүд болон хувийн тохиолдлууд ба гэрчлэлүүд дээр тулгуурлагдаж болно. Ихэнх хичээлүүд нь Аврагчийн мэндэлсэн явдал, амьдрал, сургаал номлолууд ба Цагаатгалыг тусгасан байх ёстой. *Сайн Мэдээний Зарчмууд*, *Сайн Мэдээний Үндсүүд* ба Сүмийн сэтгүүлүүд нь гэр бүлийн үдшийн хичээлд ашиглаж болох олон сэдэв болон өгүүллэгүүдийг агуулдаг.

Гэр бүлийн үдэшт доорх сэдвүүдийг ярилцахыг зөвлөмж болгож байна:

- Авралын төлөвлөгөө
- Исүсийн амьдрал болон сургаал номлолууд
- Наманчлал
- Залбирал
- Мацаг барилт
- Мэргэн Ухааны Үг
- Их Эзэний ёс суртахууны жишиг
- Ариун ёслолын утга учир
- Аравны нэг
- Талархал
- Шударга ёс
- Бурханыг бишэрч, Түүний бүтээлүүдийг хүндэтгэх
- Усан баталгаа, пристийн зэргийн ёслол, буюу гэрлэлтэнд бэлтгэх
- Ариун сүмд ороход бэлтгэх
- Судраас унших
- Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих
- Бусдыг уучлах
- Гэрчлэлтэй болох ба түүнийг хуваалцах
- Сайн мэдээг бусадтай хуваалцах
- Гэр бүлийнхээ түүхийг хөтлөх
- Үхлийг ойлгож, хүлээн зөвшөөрөх
- Гэр бүлийн асуудлуудыг шийдэх
- Гэр бүлийнхээ санхүүг зохицуулах

- Өрх гэрийн ажлаа хийлцэх
- Хөгжмийг үнэлж таашаах

Баяр Ёслол болон Онцгой Тохиолдлууд

Зул сарын баяр, Улаан Өндөгний Баяр, пристийн зэргийн дахин сэргээлтийн тэмдэглэлт ой, гэр бүлийн гишүүн номлолд явах, эсвэл төрөх, усан баталгаа, гэр бүлийн гишүүний ёслол зэрэг баяр ёслол болон онцгой тохиолдлууд нь сайн мэдээний үнэнийг заах маш сайхан боломж байж болно.

Аравны Нэг ба Өргөлүүд



Их Эзэн өөрийн хүмүүст аравны нэгийн хуулийг дагаж, амласан адислалуудыг авахад зохистой байхыг зарлигласан билээ (Малахи 3:8–11-ийг үз).

Өргөлүүд болон аравны нэгийн хуулийг заах хамгийн тохиромжтой үе нь эцэг эхчүүд энэ үед өөрсдийнхийг төлсөн байх явдал юм. Эцэг эхийнхээ юу хийдгийг харах нь хүүхдүүдэд их нөлөөлдөг.

Эцэг эхээсээ мөнгө авдаг хүүхдүүд аравны нэгээ төлөх ёстой. Хүүхэд бүр гурван хуримтлалтай байж болно: нэг нь аравны нэгт, нэг нь номлолд, нэг нь мөнгө зарцуулалтанд. Хүүхдүүд мөнгөтэй болох болгондоо эхлээд аравны нэгийн хуримтлалд 10 хувийг, тэгээд зарим хэсгийг нь номлолын, харин үлдсэнийг нь хэрэглэх мөнгөн хуримтлалд оруулж сурах ёстой.

Хүүхдүүдийг аравны нэгээ төлөх үед нь эцэг эхчүүд тэдэнд аравны нэгийн хуудсыг бөглөж мөнгөтэй хамт дугтуйнд хийж, дугтуйгаа бишопын зөвлөл, эсвэл салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүнд өгөх буюу илгээхийг заах ёстой. Хэсгийн, эсвэл салбарын нутаг дэвсгэрт амьдардаггүй гэр бүлүүд аравны нэгээ пристийн зэргийн зохих удирдагчид өгөх ёстой.

Хоолны Үеэрх Яриа

Хоолны цаг нь сайн мэдээний талаар ярих тохиромжтой үе байдаг. Бага хүүхдүүд сайн мэдээний талаар асуух болон асуултанд хариулах дуртай байдаг. Тэд хариултыг мэдэхгүй тохиолдолд эцэг, эсвэл эх нь товч хариулт өгч сайн мэдээг зааж болно. Хэдийгээр бүх хоолны үеэр сайн мэдээний талаарх ярилцлагыг өрнүүлэх хэрэггүй ч гэсэн иймэрхүү ярилцлагуудыг долоо хоногт хоёроос гурван удаа байлгах нь сайн мэдээг сурахад гэр бүлд тусалж чадна.

Унтахын Өмнө Ярьдаг Түүхүүд

Ихэнх хүүхдүүд унтахын өмнө түүх ярьж өгөхөд дуртай учраас энэ нь судар, Сүмийн хэвлэлээс түүхийг уншиж өгөх юмуу хувийн туршлагаас ярьж өгснөөр сайн мэдээг заах сайхан боломжийг олгодог. Шударга ёс, өглөгч чанар, сайхан сэтгэлийн тухай түүхүүд нь сайн мэдээний чухал зарчмуудыг заадаг.

Хамтдаа Ажиллах



Гэр бүлүүд хамтдаа гэр зуураа ажиллах явцад сайн мэдээг заах олон боломж гарч ирдэг. Гэрээ цэвэрлэх, эсвэл зүлэг арчлах юмуу цэцэрлэгтээ ажиллах явцад, жишээ нь, сайн мэдээний талаар ярих боломжинд эцэг эхчүүд сонор соргог байх хэрэгтэй. Хүүхэд үргэлж асуулт тавьдаг. Эцэг эхчүүд үргэлж энгийн хариултуудыг өгөх цаг гаргах ёстой. “Чи сайн ажиллаж байна. Тэнгэрлэг Эцэг чамаар бахархаж байгаа гэдэгт би итгэлтэй байна,” гэх юмуу, эсвэл “Тэнгэрлэг Эцэгийн бүтээсэн энэ сайхан үүлнүүдийг хар даа,” гэх

ээрэг тайлбарууд нь Тэнгэрлэг Эцэгт талархах мэдрэмж, Тэр бол жинхэнэ бодитой юм гэсэн нотолгоог хүүхдүүдэд өгч чадна.

Гэр Бүлийн Зөвлөл



Гэр бүлийн гишүүдээ хамтад нь гэр бүлийн зөвлөлийн цуглаануудад оролцуулахыг эцгүүд зохион байгуулж болно. Эдгээр зөвлөлүүдийг гэр бүлийн зорилгоо бий болгоход, гэр бүлийн асуудлаа шийдэхэд, санхүүгээ хэлэлцэхэд, төлөвлөгөө боловсруулж, бие бие нээ дэмжин хүчирхэгжүүлэхэд, мөн гэрчлэлээ хуваалцан бие бие нийхээ төлөө залбирахад гэр бүлүүд ашиглаж болно. Зөвлөлийг хэрэгтэй гэж үзсэн үед хийж болно. Эцгүүд нь гэр бүлийн зөвлөлийг Ням Гараг бүр эсвэл гэр бүлийн үдэштэй уялдуулан хийж болно. Бусдын санал сэтгэгдлийг хүндлэх нь гэр бүлийн зөвлөлийн амжилтанд чухал юм.

Ганцаарчилсан Ярилцлагууд

Олон эцэг хүүхдүүдтэйгээ ганцаарчилсан ярилцлага тогтмол хийх нь хүүхдүүдтэйгээ улам ойртон дотно болоход нь тэднийг урамшуулах мөн тэдэнд сайн мэдээг заахад нь эцгүүдэд тусалдаг гэдгийг олж мэджээ. Ийм ярилцлага нь албан ёсны болон албан ёсны бус байж болох бөгөөд байнга хийгдэх учиртай.



Эцэг хүн хүүхэддээ итгэж, хайр энэрлээ илэрхийлэх ёстой, мөн хүүхэд ямар ч сэдэв, ямар ч асуудал, эсвэл ямар ч тохиолдлын талаар өөрийн сэтгэгдлээ хэлэх боломжтой байх ёстой. Эцэг хүн эдгээрийг анхааралтай сонсож, мөн хүүхдийн асуудлыг шийдвэрлэж итгэлийг нь хүлээх хэрэгтэй. Эцэг нь хүүхэдтэйгээ хамт залбирч болно. Ярилцлагаас урган гарсан гэр бүлийн бусад гишүүдэд холбогдох асуудлуудыг гэр бүлийн дараагийн үдэшээр авч хэлэлцэж болно.

Гэр Бүлийн Үйл Ажиллагаанууд

Гэр бүлээрээ бүгдээрээ аливаа зүйлсийг байнга хамтдаа хийх цагийг эцэг хүн төлөвлөх хэрэгтэй. Зугаалга, аялал, гэр бүлийн төслүүд, гэрийн болон талбайн ажил, усанд сэлэх, мөн ашиг тустай кино болон бусад үзвэр үйлчилгээнүүд нь гэр бүлийн хамтдаа баясан цэнгэж болох олон үйл ажиллагаануудын нэгэн хэсэг нь билээ.

Аливаа үйл ажиллагаануудыг хамтран хийж байгаа гэр бүлүүд агуу их хайр болон зохицлыг мэдрэх болно. Хүүхдүүд эцэг эхтэйгээ ойр дотно байгаагаа мэдрэх үедээ тэднийг сонсож, мөн тэдний зөвлөгөөг дагахад улам илүү бэлэн байх болно. Эцэг эхчүүд сайн мэдээг улам их нөлөөтэйгөөр заах боломжтой болно.



Пристийн Зэрэгтний Үндсэн Үүргүүд



Их Эзэний Сүмийн үүрэг нь Христэд ирэхэд нь бүх хүмүүст туслах явдал юм. Гэр бүлүүд дараах зүйлсийг хийснээр энэхүү үүргийг гүйцэлдүүлэхэд тусалж чадна:

1. Өөрсдийнхөө сүнслэг болон эд материалын хэрэгцээг хангаж бусдад хэрэгцээгээ хангахад нь туслах.
2. Сайн мэдээг бусадтай хуваалцах.
3. Гэр бүлийн гишүүд ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч байгааг ажиглаж, нас барсан өвөг дээдэсдээ эдгээр адислалуудыг авахад нь туслах.

Сүнслэг болоод Эд Материалын Хэрэгцээ

Сүнслэг Хэрэгцээ

Энэ удирдамжийн өмнөх “Сайн Мэдээг Гэртээ Заах нь” хэсэгт гэр бүлүүд хэрхэн өөрсдийнхөө сүнслэг хэрэгцээг хангаж чадах тухай мэдээллийг агуулдаг.

Эд Материалын Хэрэгцээ

Гэр бүлүүд бие даах чадвартай болсноор өөрсдийн эд материалын хэрэгцээг хангах төдийгүй бусдад тусалж чадна. Бие даасан байхын тулд гэр бүлийн гишүүд ажиллах хүсэлтэй байх ёстой. Ажил нь бие махбодын, оюуны буюу сүнслэг

чармайлт байдаг. Энэ нь ололт амжилт, аз жаргал, өөрийгөө үнэлэх сэтгэл мөн чинээлэг амьдралын эх булаг юм. Эцэг эхчүүд бие даасан байхын төлөө чармайж хүүхдүүддээ мөн адил зүйлийг заах ёстой. Бие даасан байдал нь гачигдалтай байгаа бусад хүмүүст туслах боломжийг тэдэнд олгодог.

Эцгүүд амьдралынхаа хэрэгцээг хангаж, гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхчүүд үндсэндээ хүүхдүүдээ асрах үүрэгтэй байдаг. Эцэг эхчүүд нь цэвэрхэн гэр орон, сайн чанарын хоол хүнс, хувцас хунар, эмнэлгийн болон шүдний эмчилгээгээр хангагдаж, боловсролын талаарх боломжууд, санхүүгийн нөөцийг удирдах зааварчилгаа болон боломжтой бол хоол хүнсний зарим зүйлсийг хэрхэн ургуулж болох талаар суралцхад санаа тавьдаг. Хоол хүнсээ хэрхэн бэлтгэж дараа нь хэрэглэхийн тулд хэрхэн хадгалахыг эцэг эхчүүд хүүхдүүддээ заах ёстой.

Эцэг эхчүүд эдгээр эд материалын хэрэгцээг хангахын тулд шаргуу ажиллах хүсэлтэй байх ёстой. “Танар хүүхдүүдээ өлөн зэлмүүн боллоод нүцгэн явахыг зөвшөөрөхгүй байх болно” (Мозая 4:14). Өвчин эмгэг, гай гамшиг, ажилгүйдэл буюу бусад хүнд хэцүү цаг үед гэр бүлийнхээ хэрэгцээг хангахад эцэг эхчүүд бэлтгэж төлөвлөх хэрэгтэй. Хэрэв гэр бүлийнхээ эд материалын хэрэгцээг хангах нь эцгийн хувьд хэцүү, мөн гэр бүлийн бусад

гишүүд туслах чадваргүй бол пристийн зэргийн удирдагчдаар дамжуулан тусламж дэмжлэг хүсч болно.

Хүүхдүүд эцэг эхдээ ажилд нь туслах, хичээлдээ сайн сурах, өөрсдийн хувцас хунар болон бусад эд хөрөнгөндөө анхаарал тавих, өөрсдийгөө болон гэр орноо цэвэр нямбай авч явах, эрүүл саруул байснаар гэр бүлийнхээ эд материалын хэрэгцээг хангахад тусалж чадна.

Гэр бүлийн гишүүд өөрсдийн унших, бичих, энгийн тоо бодох чадварыг дээшлүүлж, мэдлэг олох, ур чадвараа сайжруулах боломж бүрийг ашиглах хэрэгтэй. Тэд Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагаж эрүүл мэндэд сайн хоол хүнс хэрэглэх хэрэгтэй. Боломжтой бол гэр бүлүүд амьдрал тэтгэх үндсэн зүйлүүдийг чадах чинээгээрээ буюу нэг жилээр нөөцлөх хэрэгтэй. Гэр бүлийн гишүүд шаардлагагүй өрнөөс зайлсхийж, ирээдүйдээ зориулан мөнгө хуримтлуулж, бүх үүрэг хариуцлагаа биелүүлэн, нөөц боломжоо дэмий үрэхээс зайлсхийж, ухаалгаар ашиглах ёстой.

Эцэг эхчүүд хүүхдүүддээ бусадтай хуваалцахыг зааж сургах ёстой. Бараг хүн болгон хичнээн бага ч хамаагүй ямар нэгэн юмыг өгч чадна. Хэрэгцээ гарсан хүмүүст туслах нэг арга бол сар бүр мацаг барин, мацаг барилтын өргөлийг хандивласнаараа өлссөнийг хооллох, орон гэргүйг орон гэртэй бол-

гох, хувцасгүйг хувцаслах, зовж шаналсныг тайтгаруулахад түүнийг хэрэглэдэг. Бид бусдад тусалснаараа Их Эзэнд хайраа үзүүлдэг. Тэрээр, “Үнэнээр би та нарт хэлье. Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол надад хийсэн хэрэг” хэмээн хэлсэн байдаг (Матай 25:40).

Сайн Мэдээнээс Хуваалцах



Их Эзэн хожмын үеийн бошиглогчдоороо дамжуулан Сүмийн гишүүн бүр сайн мэдээнээс бусадтай хуваалцах хариуцлагыг хүлээдэг хэмээн заасан билээ. “Сэрэмжлэгдсэн хүн бүхэн хөршөө сэрэмжлүүлбэл зохино” (С ба Г 88:81). Мормоны Номон дахь бошиглогч Алма “Бид усаар батлуулахдаа хэзээ ч, юунд ч, хаана ч, Бурханы гэрч болон зогсоход бэлэн байх ёстой,” гэж тайлбарлажээ (Мозая 18:9).

Есүс Христийн сайн мэдээ болон амьдралд нь ирэх адислалуудын талаар сурахад нь өөрсдийн хамаатан садан, найз нөхөд болон хөршүүддээ туслахын тулд гэр бүлийн гишүүн бүр чадах бүхнээ

хийх ёстой. Сайн мэдээнээс хуваалцсанаар эцэг эх болон хүүхдүүд гэрчлэлээ нэмэгдүүлж, сайн мэдээний адислалыг бусдад авчрах болно. Гэр бүлүүдийн хийж чадах зүйлс:

- Бүх зарлигуудыг дуулгавартай дагаснаар сайн үлгэр дуурайл үзүүлэх (Матай 5:16-г үз).
- Сүмийн гишүүнийхээ хувьд талархалтай байх (Ром 1:16-г үз), мөн гишүүн гэдгээ бусад хүмүүст мэдүүлэх.
- Сүмийн тухай илүү ихийг мэдэхийг хүсч буй эсэхийг нь танилуудаасаа асуух.
- Сайн мэдээг сонсоход бэлэн гэр бүл, эсвэл хувь хүнийг сонгоход тэдэнд туслахыг Их Эзэнээс хүсэх.
- Гэр бүл, эсвэл хувь хүнийг гэр бүлийн үдэш юмуу Сүмийн цуглаан болон үйл ажиллагаануудад урих, Сүмийн ном, товхимлуудыг уншуулахаар өгөх, эсвэл сайн мэдээний адислалуудын тухай тэдэнтэй ярилцах зэрэг ямар нэгэн арга замаар тэдгээр хүмүүст Сүмийг танилцуулах.
- Гэр бүл, эсвэл хувь хүнийг гэрт нь номлогчдоор заалгуулахыг урих.

Эцэг эхчүүд өөрсдийгөө болоод хүүхдүүдээ бүрэн цагийн номлолд үйлчлэхэд бэлтгэх үүрэгтэй. Хүүхдүүдээ, ялангуяа хөвгүүдээ номлолд явахад нь бэлтгэхийн

тулд эцэг эхчүүд гэр орондоо сайн мэдээг зааж хувиараа болон гэр бүлээрээ судраас суралцаж мөн залбиралтай байж, сайн мэдээнээс хуваалцах хариуцлага хийгээд адислалуудын талаар байнга ярьж байх хэрэгтэй. Номлолд зориулж мөнгө хуримтлуулах, шаргуу ажиллах, бие даасан байхыг мөн бусад хүмүүсийг хайрлаж тэдэнд үйлчлэх тухай хүүхдүүддээ тэд заах хэрэгтэй.

Амьд Байгаа Хүмүүс болон Нас Барагсдын Төлөө Хийх Ариун Сүмийн Ёслолууд

Ариун сүмүүдэд Сүмийн зохистой гишүүд эрхэм нандин ёслолуудыг хүлээн авч, Бурхантай гэрээ байгуулдаг. Тэд мөн нас барсан өвөг дээдсийнхээ төлөө ёслолын ажилд оролцдог. Боломжтой бол эцэг эхчүүд ариун сүмийн зөвшөөрлийг пристийн зэргийн удирдагчдаасаа авч, ариун сүмийн ёслолуудыг өөрсдөө хүлээн авахаар ариун сүм рүү явах хэрэгтэй. Хэрэв тэд ариун сүм рүү явах боломжгүй бол ариун сүмийн зөвшөөрөл авахуйц зохистойгоор амьдрах ёстой.

Гэр бүлүүд ариун сүмийн ёслолуудыг хүлээн авалгүйгээр нас барсан өвөг дээдсийнхээ төлөө тэдгээр ёслолууд хийгдсэн эсэхийг хянах ариун нандин үүрэгтэй. Өөрсдийн ёслолуудыг хүлээн авсан Сүмийн

гишүүд өвөг дээдсийнхээ төлөө ёслолуудыг гүйцэтгэхээр цаг зав, учир үндэслэл болон ариун сүмийн хүч чадлыг харгалзан тухай бүр ариун сүм рүү явах хэрэгтэй.



Эцэг эхчүүд өөрсдийнхөө болон хүүхдүүдийнхээ амьдралд тохиолдох чухал үйл явдлуудыг бичсэн тэмдэглэлүүдийг адислал, усан баталгаа, томилолт, гэрлэлт болон нас барсны гэрчилгээ, чухал захиа, зураг, сонины хайчилбарууд болон үүнтэй адил бусад зүйлийг цуглуулах хэрэгтэй. Тэд хувийн түүхээ эмхэтгэн гэр бүлийн гишүүн бүрийг хувийн түүх хөтлөхийг урамшуулах нь зүйтэй. Тэд хувийн намтар түүхээ хөтөлж эхлэхэд нь бага балчир хүүхдүүддээ туслах хэрэгтэй.

Гэр бүлүүд өвөг дээдсийнхээ тухай мэдээллийг цуглуулж гэр бүлийн түүхэндээ эмхэтгэж хийх ёстой. Тэд сүүлийн дөрвөн үе удмынхаа мэдээллийг эмхтгэн цуглуулахаас эхлэх ёстой.

Удирдлагын Сургалт



Номлол, дүүрэг, эсвэл гадасны удирдагчдын удирдлага дор чуулга ба бүлгийн пристийн зэргийн удирдагчид өөрсдийн удирдан тэргүүлж байгаа эцэг бүрт гэр бүл дэх пристийн зэргийн гурван гол үүргийг ойлгож, биелүүлэхийг заах ёстой (12–15-р хуудсыг үз). Пристийн зэргийн удирдагчид эцэг бүрт гэр бүлээ Сүмийн нэгж болохынх нь хувьд хэрхэн удирдахыг заах хэрэгтэй. Хэрэв гэр бүл нь салбар юмуу хэсгийн нутаг дэвсгэрт амьдрадаггүй бол номлол, дүүрэг, эсвэл гадасны удирдагчид эцгүүдийг үүргээ суралцаж биелүүлж байгаа эсэхэд анхаарал тавьж байх ёстой.

Гэр Бүл Сүмийн Нэгж Болох нь



Зарим гэр бүлүүд бүлэг, салбар, эсвэл хэсэгт хамрагддаггүй. *Ном.лол, дүүрэг, эсвэл гадасны ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр* иймэрхүү гэр бүлүүд Ням Гарагийн бишрэлийн үйлчлэлүүдийг гэртээ үйлдэж болно. Эцэг нь зохих пристийн зэргийг атгадаг бол гэр бүл нь Сүмийн нэгж болохын хувьд үйл ажиллагаагаа явуулдаг. Эцэг юмуу өөр нэг пристийн зэрэгтэн, хэрэв тэрээр зохистой бол, Аароны Пристийн Зэрэгтэй юмуу Мелкизедек пристийн зэргийг атгадаг бол, *мөн пристийн зэргийн удирдагчаасаа зөвшөөрөлтэй* бол ариун ёслолыг бэлтгэн адислаж болно. Ямар ч пристийн зэрэгтэн ариун ёслолыг түгээж болно.

Ариун ёслолыг гүйцэтгэх тухай зааварчилгаа энэхүү удирдамжийн 21–23 хуудсанд бий.

Ням Гарагийн бишрэлийн үйлчлэл нь энгийн, сүсэг бишрэлтэй мөн хүндэтгэлтэй байх ёстой. Энэ нь дараах зүйлүүдээс бүрдэж болно:

1. Нээлтийн дуулал
2. Нээлтийн залбирал
3. Ариун ёслолыг адислах ба түгээх
4. Дараах зүйлүүдийн аль нэг нь буюу хэд хэд нь байж болно:
 - Нэг юмуу хоёр товч яриа, эсвэл гэрчлэл
 - Гэр бүлээрээ судраас уншиж ярилцах

- Гэр бүлийн нэг гишүүн хичээл заах

5. Хаалтын дуулал

6. Хаалтын залбирал

Эцэг хүн Ням Гарагийн бишрэлийн үйлчлэлийг төлөвлөхдөө Их Эзэний Сүнсний удирдамжийг эрэлхийлж дагах ёстой. Мормоны Номон дахь хүмүүс иймэрхүү үйлчлэлийн жишээг үзүүлсэн байдаг. “Тэд хурал цуглаануудаа Ариун Сүнсний хүч чадал болон Сүнсээр хөтлөн явуулж мөн тэр хүч тэднийг хөтлөх үед тэд номлон, ухуулж, залбирч, даруухан залбиралдаа хүслээ хэлж, дуулж байлаа” (Моронай 6:9-ийг үз).

Гэр бүл судруудыг үндсэн удирдамжаа болгон ашиглах ёстой. Түүнчлэн тэд ерөнхий чуулганы илтгэлүүд, *Сайн Мэдээний Үндсүүд*, *Gospel Principles*, номлогчийн товхимолууд, Сүмийн сэтгүүлүүд ба Сүмийн бусад хэвлэлүүд болон видео үзүүлэн таниулах материалуудыг ашиглаж болно.

Хэрэв гэр бүлд зохих пристийн зэргийг атгагч байхгүй бол хамтдаа дуулал дуулах, судраас сурал-

цах, залбирах мөн бие биедээ болон Тэнгэрлэг Эцэгт улам ойр дотно болгохын тулд эцэг эх нь гэр бүлийн гишүүдийг цуглуулж болно. Гэр бүлийн томилогдсон пристийн зэргийн удирдагч нь гэр бүлээ ариун ёслолыг хүртэх боломжтой тогтмол цагийг товлодог.

Ууланд авирах, зугаалгаар явах, үр өгөөжтэй кино үзэх, төрөл садныхаараа айлчлан очих, спорт, хөгжмийн хөтөлбөрүүд болон усанд сэлэх гэх мэт үйл ажиллагаануудыг ажлын аль нэг өдөр эцэг эхчүүд хийх хэрэгтэй.

Хэсэг юмуу салбарт хамаарагддаггүй гэр бүл аравны нэг, мацаг барилтын өргөлүүд болон бусад хандивуудыг гэр бүлээс томилогдсон пристийн зэргийн удирдагчид өгөх хэрэгтэй.

Гэр бүлүүд тайлангаа Сүмд амаар тавидаг ч гэсэн, боломжтой бол эцэг нь томилогдсон пристийн зэргийн удирдагчтай пристийн зэргийн үүрэг даалгаврын ярилцлагыг дор хаяж улиралд нэг удаа хийж, гэр бүлийнхээ байдлыг мэдээлэх нь зүйтэй.

Пристийн Зэргийн Ёслолууд ба Адислалууд



Пристийн зэргийн ёслолууд нь Их Эзэнээр өгөгдөж пристийн зэргийн эрх мэдлээр гүйцэтгэгддэг ариун нандин үйл юм. Пристийн зэргийн адислалууд нь эдгээх, тайтгаруулах болон урамшуулан дэмжихэд пристийн зэргийн эрх мэдлээр өгөгддөг. Адислалууд болон Ёслолуудыг гүйцэтгэдэг ах нар сайн мэдээний зарчмуудын дагуу амьдарч Ариун Сүнсээр удирдуулахыг хичээснээр өөрсдийгөө бэлтгэх хэрэгтэй. Тэд ёслол, адислал бүрийг хүндэтгэлийн байдалтайгаар дараах шаардлагуудын дагуу гүйцэтгэх ёстой. Ёслолыг,

1. Есүс Христийн нэрээр гүйцэтгэх.

2. Пристийн зэргийн эрх мэдлээр гүйцэтгэх.
3. Онцлон заагдсан үгсийг хэлэх, эсвэл ариулсан тос хэрэглэх зэрэг шаардагдах журам горимын дагуу гүйцэтгэх.
4. Шаардлагатай бол тохирох түлхүүрүүдийг атгагч, томилогдсон пристийн зэргийн удирдагч зөвшөөрсөн байх ёстой.

Хүүхдүүдийг нэрлэх, адислах, усан баталгаа болон баталгаануудыг гүйцэтгэх, пристийн зэрэг олгох болон пристийн зэргийн албан тушаалд томилгох, ариун ёслолыг адислах, түгээх болон булшийг онцгойлон адислах нь пристийн зэргийн удирдагчийн зөвшөөрөл шаардагдах ёслолууд юм.

Энэ хэсэгт тайлбарласан ёслол болон адислалууд нь гэр бүлдээ патриархын хувьд үйлчлэхэд нь эцгүүдэд туслах болно.

Хүүхэд Нэрлэх ба Адислах



“Христийн Сүмийн хүүхэдтэй гишүүн бүр хүүхдээ сүм рүү Есүс Христийн нэрээр толгой дээр нь гар тавиулан Аврагчийн нэрээр адислуулахаар ахлагч нарт авчрах ёстой” (С ба Г 20:70). Энэхүү илчлэлтэй уялдуулан зөвхөн Мелкизедек Пристийн Зэргийг атгагч зохистой эрчүүд л хүүхдүүдийг нэрлэх, адислахад оролцоно. *Хүүхдүүдийг нэрлэх, адислах ёслол нь ерөнхийлөн удирдах эрх мэдэлтнээс зөвшөөрөл шаарддаг.*

Нялх хүүхдийг адислах үед Мелкизедек Пристийн Зэргийг атгагч эрчүүд тойрог болон зогсож гар дээрээ хүүхдийг барьдаг. Том болсон хүүхдийг адислаж байгаа үед ах нар гараа хүүхдийн толгой дээр зөөлхөн тавьдаг. Адислал өгч буй хүн:

1. Тэнгэрлэг Эцэгтээ хандана.
2. Адислал нь Мелкизедек Пристийн Зэргийн эрх мэдлээр өгөгдөж байгааг хэлнэ.
3. Хүүхдэд нэр өгнө.
4. Пристийн Зэргийн адислалыг Сүнсний зааврын дагуу өгнө.
5. Есүс Христийн нэрээр дуусгана.

Усан Баталгаа



Ерөнхийлөн удирдах эрх мэдэлтний удирдлага дор зохистой прист, эсвэл

Мелкизедек Пристийн Зэргийг атгагч эрэгтэй хүн усан баталгааг гүйцэтгэж болно. Үүнийг гүйцэтгэхийн тулд тэрээр:

1. Усаар батлуулах хүний хамт усан дотор зогсоно.
2. Ая тух болон аюулгүй байдлын үүднээс тухайн хүнийхээ баруун бугуйг зүүн гараараа барьж, усаар батлуулж буй хүн зүүн гараараа усан баталгаа гүйцэтгэж байгаа хүний зүүн бугуйг барина.
3. Баруун гараа тохойгоор нь нугалан дээш өргөнө.

4. Тухайн хүний бүтэн нэрийг хэлж “Есүс Христийн итгэмжилснээр би таныг Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр усаар баталж байна. Амэн” гэж хэлнэ (С ба Г 20:73).

5. Эвтэйхэн байлгахын тулд тухайн хүний хамрыг баруун гараар нь чимхүүлж усан баталгаа гүйцэтгэж байгаа хүн баруун гараа уг хүний ар нурууны хэсэгт байрлуулж түүнийг хувцастай нь бүрэн дүрнэ.

6. Уснаас гарахад нь уг хүнд тусална.

Хоёр прист, эсвэл Мелкизедек Пристийн Зэргийг атгагч эрэгтэйчүүд усан баталгаа бүрийг зохих горимын дагуу гүйцэтгэснийг батлан гэрчилдэг. Хэрэв хэлэх үгс нь Сургаал ба Гэрээнүүд 20:73-т өгөгдсөний адилаар яг хэлэгдээгүй бол, эсвэл тухайн хүний биеийн хэсэг юмуу хувцас нь усанд бүхлээрээ дүрэгдээгүй бол усан баталгаа дахин хийгдэх ёстой. Усаар батлуулж байгаа болон усаар баталж байгаа хүмүүс норохдоо нэвт гэрэлтэхгүй цагаан хувцас өмсөх ёстой.

Баталгаа

Найм ба түүнээс дээш насны, мөн эцэг эх нь хоёулаа гишүүн биш найман настай усаар батлуулагчдыг ариун ёслолын цуглааны үеэр баталдаг (С ба Г 20:41-ийг үз). Эцэг эхийн нэг нь гишүүн бөгөөд усан



баталгаа болон гишүүнээр батлуулахыг хоёулаа зөвшөөрсөн бол найман настай хүүхдүүдийг усаар батлуулсных нь дараа газар дээр нь шууд баталж болно. *Салбарын ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор* нэг буюу түүнээс дээш тооны Мелкизедек Пристийн Зэргийг атгагч хүмүүс энэхүү ёслолыг гүйцэтгэж болно. Тэд уг хүний толгой дээр гараа зөөлөн тавина. Ёслолыг гүйцэтгэж буй хүн:

1. Уг хүний бүтэн овог нэрийг хэлнэ.
2. Ёслол нь Мелкизедек Пристийн Зэргийн эрх мэдлээр гүйцэтгэгдэж байгааг хэлнэ.
3. Уг хүнийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батална.
4. “Ариун Сүнсийг хүлээн авна уу” гэсэн үгийг хэлэн Ариун Сүнсний бэлгийг өгнө.
5. Сүнсний удирдамжаар пристийн зэргийн адислалыг өгнө.
6. Есүс Христийн нэрээр дуусгана.

Пристийн Зэргийг Олгох болон Пристийн Зэргийн Албан Тушаалд Томилох



Салбарын ерөнхийлөгч Аароны Пристийн Зэрэг олгох болон дикон, багш болон пристийн албан тушаалд томилохыг хянадаг. Аароны Пристийн Зэргийн албан тушаалд томилогдохоосоо өмнө уг хүн нь салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилцлаганд орж, зохистойгоо тогтоолгосон байх ёстой. Мөн түүнийг салбарын ариун ёслолын цуглаан дээр батлах ёстой. Салбарын ерөнхийлөгчийн зөвшөөрлийн дагуу прист нь Аароны Пристийн Зэргийг өөр хүнд өгч, Аароны Пристийн Зэргийн албан тушаалд томилж болно.

Номлолын ерөнхийлөгч Мелкизедек Пристийн Зэргийг олгох болон ахлагчийн албан тушаалд томилохыг хянадаг.

Пристийн Зэргийг олгох эсвэл пристийн зэргийн албан тушаалд томилоход нэг эсвэл түүнээс дээш тооны шаардагдах пристийн

зэрэгтэй *ерөнхийлөн удирдах эрх мэдэлтний зөвшөөрөлтэй* эрэгтэйчүүд уг хүний толгой дээр гараа зөөлөн тавина. Ёслолыг гүйцэтгэж байгаа хүн:

1. Уг хүний бүтэн овог нэрийг хэлнэ.
2. Томилолтийг гүйцэтгэж байгаа эрх мэдлийг (Аароны, эсвэл Мелкизедек Пристийн Зэрэг) хэлнэ.
3. Өмнө нь олгогдож байгаагүй бол Аароны юмуу Мелкизедек Пристийн Зэргийг олгоно.
4. Уг хүнийг Аароны юмуу Мелкизедек Пристийн Зэргийн албан тушаалд томилж, уг албан тушаалын эрх, хүч чадал болон эрх мэдлийг олгоно.
5. Сүнсний удирдамжаар пристийн зэргийн адислалыг өгнө.
6. Есүс Христийн нэрээр дуусгана.

Ариун Ёслол

Ариун ёслол нь маш эрхэм нандин ёслол юм. Ариун ёслолоос хүртэх нь Есүс Христийн амьдрал, сургаал номлол болон Цагаатгалыг дурсан санах боломж олгодог. Энэ нь усан баталгаан дээрээ Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ дахин шинэчлэх цаг билээ (Мозая 18:8–10-ыг үз).

Багш нар, пристүүд нь ариун ёслолыг бэлтгэж, пристүүд адислаж, дикон, багш, пристүүд үүнийг түгээж болно. Мелкизедек Пристийн Зэрэгтэй ах нар ариун ёслолыг

бэлтгэж, адислаж, түгээж болох боловч ер нь Аароны Пристийн Зэрэгтэй ах нар цөөхөн байх тохиолдолд үүнийг хийдэг. Ноцтой нүгэл үйлдсэн хүн нүглээ наманчилж, хэрэг явдлыг салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилцаж шийдвэрлэлтээ ариун ёслолыг бэлтгэж, адислаж, түгээх ёсгүй.



Ариун ёслолыг бэлтгэж, адислаж, түгээж байгаа хүмүүс энэ ёслолыг Их Эзэний өмнөөс бусдад үйлдэж байгаа юм. Пристийн зэрэгтэй хүн бүр хүлээсэн энэ үүрэгтээ чин сэтгэл, гүн бишрэлтэйгээр хандах ёстой. Мөн үс гэгзгээ янзалж, цэвэр даруухан хувцаслах ёстой. Хувь хүний гадаад төрх байдал нь ёслолын ариун нандин байдлын тусгал болох ёстой.

Ариун ёслолыг бэлтгэх ах нар үүнийг цуглаан эхлэхээс өмнө хийх ёстой. Тэд талхны цэвэр тавиур дээр тавьсан хуваагаагүй талх болон цэвэр устай ариун ёслолын аягануудыг тавиурт тавьж ариун ёслолын ширээн дээр байрлуулдаг. Тэд талх болон усыг цэвэр цагаан даавуугаар бүтээдэг.

Ариун ёслолын дууллын үеэр ариун ёслолын ширээний дэргэд байгаа хүмүүс талхтай тавиураас бүтээлгийг авч, талхыг жижиг хэсэг болгон хуваадаг. Дууллын дараа талхыг адислах хүн өвдөг сөгдөн талхны ариун ёслолын залбирлыг хэлдэг. Дараа нь ах нар бишрэл хүндэтгэлтэй сууж байгаа хүмүүст талхыг түгээдэг.

Цуглааныг ерөнхийлөн удирдаж байгаа хүн ариун ёслолоос эхэлж хүртдэг. Оролцож байгаа хүн бүр талхыг хүртсэний дараа ариун ёслолыг түгээгч хүмүүс тавиурыг ариун ёслолын ширээнд буцааж аваачна. Талхыг түгээж дуусангуут ариун ёслолыг адислаж байгаа хүмүүс тавиурыг бүтээнэ.

Ариун ёслолын ширээний дэргэд байгаа хүмүүс устай тавиураас бүтээлгийг авна. Усыг адислах хүн сөгдөн усны ариун ёслолын залбирлыг хэлдэг. Дараа нь ах нар тэнд ирсэн хүмүүст усыг түгээнэ. Дараа нь тавиурыг ширээн дээр буцааж тавьж, дахин бүтээнэ. Ариун ёслолыг адислаж, түгээсэн ах нар бусдын дунд байраа эзлэн сууна.

Ариун ёслол нь хүүхдүүдийг оролцуулан Сүмийн гишүүдэд зориулагдсан. Цуглааныг удирдаж байгаа хүн үүнийг зөвхөн гишүүд хүртэх ёстой гэж зарлаж болохгүй бөгөөд гишүүн бус хүмүүсийг хүртэх боломжгүй болгох юу ч хийх учиргүй.

Ариун ёслолын залбирлыг цэвэр, тод, нягт нарийн, төлөв байдалтайгаар хэлдэг. Хэрэв ариун ёслолыг адислах хүн үгийн алдаа гаргаад, түүнийгээ өөрөө засаж хэлэхгүй бол салбарын ерөнхийлөгч түүнээс залбирлыг давтан, зөв болгохыг хүсдэг.

Дараах нь талхны залбирал:

“Бурхан минь, Мөнхийн Эцэг минь, энэ талхнаас хүртсэн хэн бүхэн таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсахын тулд, таны Хүүгийн нэрийг хүлээн авч, түүнийг ямагт дурсан санаж, мөн тэдэнд хайрласан зарлигуудыг нь дагахаа Бурхан, Мөнхийн Эцэг таны өмнө гэрчлэхийн тулд, түүний Сүнсийг тэдэнтэй үргэлж хамт байлгахын тулд энэ талхыг та адислан ариулж өгөхийг таны Хүү, Есүс Христийн нэрээр бид залбирч байна. Амэн” (С ба Г 20:77 ба Моронай 4).

Дараах нь усны залбирал:

“Бурхан минь, Мөнхийн Эцэг минь, энэ уснаас хүртсэн хэн бүхэн тэдний төлөө асгаруулсан таны Хүүгийн цусыг төлөөлөн дурсахын тулд, мөн түүнийг ямагт дурсан санаж байгаагаа Бурхан, Мөнхийн Эцэг таны өмнө гэрчлэхийн тулд, түүний Сүнсийг тэдэнтэй хамт байлгахын тулд энэ [усыг] та адислан ариулж өгөхийг таны Хүү, Есүс Христийн нэрээр бид залбирч байна. Амэн” (С ба Г 20:79 ба Моронай 5).

Ариун ёслол нь цуглааны дараа ширээнээс аль болох хурдан хураагдсан байх ёстой. Үлдсэн талхыг хоол хүнсэнд хэрэглэж болно.

Ариун ёслолыг адислаж, түгээх эрхийг ерөнхийлөн удирдах эрх мэдэлтэн өгөх шаардлагатай байдаг.

Тосыг Ариулах

Мелкизедек Пристийн Зэргийг атгасан эрэгтэй нэг болон түүнээс дээш хүмүүс өвчтөнг эсвэл зовж шаналсныг тослох ариун зорилгын үүднээс чидуны цэвэр тосыг ариулдаг. Тосыг ариулж байгаа хүн:

1. Чидуны тостой савыг онгойлгон барина.
2. Тэнгэрлэг Эцэгтээ хандана.
3. Тэр Мелкизедек Пристийн Зэргийн эрх мэдлээр үйлдэж байгаагаа хэлнэ.
4. (Савыг биш) тосыг ариулж өвчтөн болон зовж шаналсныг тослохоор дусаана.
5. Есүс Христийн нэрээр дуусгана.

Өвчтөнийг Адислах



Зөвхөн Мелкизедек Пристийн Зэргийг атгагч эрэгтэйчүүд л өвчтөн эсвэл зовсныг адислаж болно. Ер нь бол хоёр ба түүнээс дээш гүйцэтгэгч адисладаг ч гэсэн, нэг нь ганцаараа гүйцэтгэж болно. Хэрэв ариулсан тос байхгүй бол Мелкизедек Пристийн Зэрэгтэй хүн пристийн зэргийн эрх мэдлээр адислал өгч болно.

Мелкизедек Пристийн Зэргийг атгагч эцэг хүн гэр бүлийнхээ өвчтэй гишүүнийг адислах ёстой. Тэрээр Мелкизедек Пристийн Зэргийг атгасан өөр нэг хүнийг туслуулахаар урьж болно.

Өвчтөнийг адислах нь хоёр хэсэгтэй байдаг. (1) Тосоор тослох, (2) тосолгооны баталгаа.

Тосоор Тослох

Мелкизедек Пристийн Зэргийг атгасан нэг хүн өвчтэй хүнийг тосолно. Ингэхийн тулд тэрээр:

1. Уг хүний толгой дээр ариулсан тосноос дусаана.
2. Тухайн хүний толгой дээр гараа зөөлөн тавьж бүтэн овог нэрийг нь хэлнэ.
3. Мелкизедек Пристийн Зэргийн эрх мэдлээр тэр хүнийг тосолж байгаагаа хэлнэ.
4. Өвчтөн эсвэл зовсныг адислаж тослохын тулд ариулсан тосоор тосолж байгаагаа хэлнэ.
5. Есүс Христийн нэрээр дуусгана.

Тосолгооны Баталгаа

Ер нь хоёр ба түүнээс дээш Мелкизедек Пристийн Зэргийг атгагч эрэгтэйчүүд өвчтэй хүний толгой дээр гараа зөөлөн тавьдаг. Эрчүүдийн нэг нь тосолгоог батална. Ингэхийн тулд тэрээр:

1. Уг хүний бүтэн овог нэрийг хэлнэ.
2. Мелкизедек Пристийн Зэргийн эрх мэдлээр тосолгооны баталгаа хийж байгаагаа хэлнэ.
3. Сүнсний удирдамжаар адислалыг өгнө.
4. Есүс Христийн нэрээр дуусгана.

Эцгийн Адислал, Тайтгарал, Зөвлөмжийн болон Бусад Адислалууд



Эцгийн Адислал мөн пристийн зэргийн бусад адислалууд нь Сүнсээр хөтлөгдөн, чиглэл болон тайтгарлыг өгдөг.

Мелкизедек Пристийн Зэрэгтэй эцэг хүүхдүүддээ эцгийн адислалыг өгч болно. Иймэрхүү адислал

нь, ялангуяа хүүхдүүд нь гэрээсээ хол сургуульд эсвэл номлолд явах, эсвэл тэднийг ажилд орох, гэрлэх, цэрэгт мордох эсвэл ердийн биш хувийн бэрхшээлтэй тулгарах зэрэгт тустай байдаг. Эдгээр адислалууд нь гэр бүлд агуу хүчийг өгч чадна. Гэр бүл нь эцгийн адислалыг гэр бүлийн бичээст тэмдэглэж болох ч гэсэн, Сүмийн бүртгэлд хадгалагдахгүй. Хэрэгтэй үедээ эцгийн адислалыг авахад нь эцэг эхчүүд хүүхдүүдээ урамшуулах ёстой.

Түүнчлэн Мелкизедек Пристийн Зэрэгтэй зохистой эрэгтэйчүүд эхнэр, хамаатан садан болон бусад хүссэн хүмүүст тайтгарал, зөвлөмжийн адислалуудыг өгч болно.

Мелкизедек Пристийн Зэрэгтэй хүн ганцаараа эсвэл нэг буюу түүнээс дээш Мелкизедек Пристийн Зэрэгтэй зохистой эрэгтэйчүүдтэй хамт эцгийн адислал буюу тайтгарал, зөвлөмжийн бусад адислалуудыг өгөхдөө адислал авч буй хүний толгой дээр гараа зөөлөн тавина. Ийм адислал өгөхөд тос хэрэглэх шаардлагагүй. Адислал өгч буй хүн:

1. Уг хүний бүтэн овог нэрийг хэлнэ.
2. Мелкизедек Пристийн Зэргийн эрх мэдлээр адислалыг өгч байгаагаа хэлнэ.
3. Сүнсний удирдамжаар адислалыг өгнө.
4. Есүс Христийн нэрээр дуусгана.

Булшийг Онцгойлон Адислах

Булшийг онцгойлон адислаж буй хүн Мелкизедек Пристийн Зэргийг атгасан, мөн *үйлчлэлийг удирдаж буй пристийн зэрэгтний албан тушаалтны зөвшөөрөлтэй байх ёстой.*

Булшийг онцгойлон адислахдаа тэрээр:

1. Тэнгэрлэг Эцэгтээ хандана.
2. Мелкизедек Пристийн Зэргийн эрх мэдлээр булшийг онцгойлон адислаж байгаагаа хэлнэ.
3. Талийгаачийн цогцсыг амар тайван байлгах газар болгохын тулд шарилын газрыг онцгойлон адислаж ариулна.
4. Тохиромжтой бол, тэрхүү газрыг Дахин Амилалт хүртэл ариун байлгаж хамгаалахын төлөө залбирч болно.
5. Гэр бүлийг нь тайтгаруулахыг Их Эзэнээс гуйн мөн Сүнсний удирдамжийн дагуу бусад бодлоо илэрхийлнэ.
6. Есүс Христийн нэрээр дуусгана.

Хэрэв гэр бүл нь илүү тохиромжтой гэж үзвэл (Мелкизедек Пристийн Зэрэгтэй хүн байх нь илүү тохиромжтой) тухайн хүн онцгойлон адислах залбирлын оронд булшны дэргэдэх залбирлыг хэлсэн нь дээр юм.

Сүмийн Материалуудыг Олж Авах ба Гэр Бүлийн Түүхийн Тухай Мэдээлэл Цуглуулах нь

Орон нутгийн удирдагчид болон бусад гишүүд судар, суралцах цуврал гарын авлага, Сүмийн сэтгүүл, гармент, ариун сүмийн хувцас зэрэг Сүмийн эд зүйлийг Сүмийн хангамжийн төв буюу үйлчилгээний төв, Солт Лэйкийн Хангамжийн Төвөөс эсвэл www.lds.org дахь Сүмийн албан ёсны Интэрнетийн мэдээнээс олж авч болно.

Гэр бүлийн түүхийн ажлын тухай мэдээллийг www.familysearch.org дахь Сүмийн гэр бүлийн түүхийн Интэрнетийн мэдээнээс олж авах боломжтой.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

